

## **УИХ-ын 2012 оны Сонгуулийн сурталчилгааны мониторинг**

Глоб Интернэшнл ТББ нь УИХ-ын 2012 оны сонгуулийн сурталчилгаанд хэвлэл мэдээллийн мониторинг хийж байна. СЕХ-оос товлосон хуваарийн дагуу сонгуулийн сурталчилгаа явуулах 2012 оны 6 дугаар сарын 6-26-ны хооронд үргэлжлэх 3 үе шаттай энэ мониторингийн зорилго нь “Телевиз радио нь сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэхдээ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.14 хэсэгт заасны дагуу сонгуулийн сурталчилгааны тэнцвэрт байдлыг хангаж, олон нийтэд үнэн зөв, бодит мэдээллийг хүргэж, редакцийн хараат бус байдлыг ханган, сэтгүүл зүйн мэргэжлийн зарчим, ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих явдал.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэв. Үүнд:

- ✓ Олон нийтийн телевиз нь сонгуулийн сурталчилгаатай холбогдсон сурталчилгааны нэвтрүүлгийг СЕХ-оос тогтоосон хуваарь, цагийн дагуу зөвхөн төлбөргүй нэвтрүүлж байгаа эсэх
- ✓ Тэнцвэртэй сурталчилгаа
  - Цаг хуваарилалт
  - Мэдээллийн өнгө аяс
- ✓ Сонгуулийн хараат бус сэтгүүл зүйн нэвтрүүлгийн цаг, чанарыг тодорхойлох
  - Мэдээний хөтөлбөр
  - Сонгогчдын боловсролд зориулсан мэдээллийн тусгай хөтөлбөр
  - Мэтгэлцээн
- ✓ Олон нийтийн телевизээс бусад телевизийн сурталчилгааны төлбөртэй нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт хоёр цагаас илүүгүй байгаа эсэх
- ✓ СЕХ, ХХЗХ-оос гаргасан журмын 3.1-д заасныг зөрчиж аливаа хэлбэрийн далд сурталчилгаа явуулж байгаа эсэхийг илрүүлэх зэрэг болно.

Мониторингд МҮОНТ, UBS, MN25, ТВ5, ТВ9 телевизүүд хамрагдсан бөгөөд судалгаанд хамрагдах телевизүүдийг олон нийтийн буюу төсвийн санхүүжилт ашигладаг, орон даяар цацагддаг, үзэгчдийн тоо, рейтинг өндөр, зах зээлд удаан үйл ажиллагаа явуулж байгаа гэсэн шалгууруудыг үндэслэн сонгов.

# МҮОНТ

## Мониторингийн 2-р хэсэг

/6 дугаар сарын 12-19/

Сонгуулийн сурталчилгаа явуулах 21 хоногийн хугацаанд МҮОНТ нь 13 нам эвсэл болон бие даагчдад нийтдээ 23 цаг зарцуулахаар төлөвлөжээ. Цагийг хуваарилахдаа 21 өдөрт хувааж нам тус бүр 3 удаагийн давтамжтайгаар 20 минутын нэвтрүүлэгт оролцохоор төлөвлөсөн байна. Энэ нь нийт 13 цагийг эзэлж байгаа юм. Үлдсэн 10 цагийг хуваарилахдаа Бие даагчдад дангаар нь 1 цаг 30 минутын эрх олгож үлдсэн 8 цаг 30 минутыг дахин 13 нам, эвсэлд тэнцүү оролцоотойгоор хуваарилсан нь нэг намд дунджаар 40 орчим минутын хугацаа оногдож байгаа юм. Судалгааны явцад урьдчилан гаргасан хуваарийн дагуу тулгалт хийхэд төлөвлөсний дагуу ямар ч зөрөөгүй ажиллаж байв. Гэвч хуваарьт цагаас бусад цагт харилцан адилгүй байна.

1. Судалгааны хугацаанд МҮОНТ-ийн 141:14:08 цагийн бичлэгт мониторинг хийснээс 14:32:27 цаг нь сонгуулийн сурталчилгаатай холбогдсон мэдээлэл байна. Энэ нь нийт эфирийн цагийн 10%-ийг эзэлж байна.

МҮОНТ-ийн сонгуулийн мэдээллийн 22%-ийг АН, 20%-ийг МАН эзэлсэн нь тун ойролцоо байсан бол МНН-д 10%-ийн цаг оногдсон нь бусдаасаа өндөр хувь эзэлжээ. Харин ИЗНН, МУНН, ХХН, ИХН, Гурав дахь хүчин эвсэл, ЭЧХН намуудад адил тэнцүү 5%, Шударга ёс эвсэл, ЭОНН, МСДН, ЭОН-уудад адилхан 4% оногдсон байна. *МҮОНТ нь Бие даагчдад 3%-тай тэнцэх хугацаа оноожээ.*

2. Сонгуулийн сурталчилгааны 14:32:27 цагийн нэвтрүүлгийн 05:24:21 цагийн нэвтрүүлэг нь аль нэг нам эвсэл, нэр дэвшигчийн тухай бус цэвэр сонгогчдын боловсролд зориулсан агуулгатай мэдээлэл байжээ. Энэ нь сонгуулийн тухай мэдээллийн 37%-ийг эзэлж байгаа юм. Энэ нь 1-р хэсэгтэй харьцуулахад 15%-иар өссөн байна.

3. Сонгуулийн сурталчилгаатай холбоотой нэвтрүүлсэн мэдээллийн эх сурвалжийн байдлыг авч үзвэл 77% нь шууд, 23% нь шууд бус эх сурвалжаас хүрчээ.

4. МҮОНТ-ийн мэдээллийн чанарыг үнэлэхэд дийлэнх нь буюу 90% нь эерэг хандлагатай, 8% нь төвийг сахисан өнгө аястайгаар мэдээлжээ. Сөрөг аястай мэдээлэл ердөө 2 минут эзэлсэн нь нийт мэдээллийн 2%-д ч хүрэхгүй юм. Үүнийг 1-р хэсэгтэй харьцуулахад эерэг мэдээлэл өсч харин төвийг сахисан мэдээлэл 14%-иар буурсан нь харагдаж байна. Харин сөрөг мэдээлэл 1%-иар нэмэгджээ.

Эерэг өнгө аястай мэдээллийн тал шахам буюу 21% нь АН-д, 18% нь МАН-д, 11% нь МНН-д, 6% нь МУНН-д оногджээ. ЭОНН, ИХН, ЭЧХН, Гурав дахь хүчин эвсэл, ИЗНН-уудад адилхан 5% оногдсон бол, ХХН, Шударга ёс эвсэл, МСДН, ЭОН-уудад тус бүр 4% оногдов. Бие даан нэр дэвшигчдэд бусдаасаа хамгийн бага буюу 3%-ийн цагийг зарцуулсан байна.

Тус телевиз МАН-ыг хамгийн их төвийг сахисан байдлаар мэдээлжээ. Энэ нь нийт төвийг сахисан мэдээллийн 36%-ийг эзэлсэн бол АН-ын төвийг сахисан мэдээлэл 21%-ийг эзэлжээ. Буурсаар Шударга ёс эвсэл-д 9%, ХХН-д 7%, ИЗНН-д 6%, Гурав дахь хүчин эвсэл, МУНН-д адилхан 5%, ЭЧХН-д 3%, ЭОН-д 2% тус тус оногджээ. ЭОНН-ын талаар 8

секунд төвийг сахисан байдлаар мэдээлсэн нь 1%-д хүрэхгүй байна. Харин ИХН-ын талаар төвийг сахисан байдлаар мэдээлээгүй байна.

Сөрөг өнгө аястай мэдээлэл харьцангуй бага илэрсэн нь ердөө 6 минут 33 секунд байв. Үүний 89% нь МАН-д оногджээ. ЭОН-ын талаар 23 секундын сөрөг мэдээлэл цацсан нь 6%-ийг эзэлж, үлдсэн 5%-нь Шударга ёс эвслийн талаарх мэдээ байжээ.

5. Сонгуулийн сурталчилгаатай холбоотой нэвтрүүлгийн 60% нь оргил цагт, 40% нь энгийн цагт цацагдсан байна. 1 дүгээр хэсгийн судалгааны дүнтэй харьцуулахад сонгуулийн тухай мэдээллээ оргил цагт өгөх нь 12%-иар нэмэгдсэн байна.

Оргил цагийн нэвтрүүлгийг субъектуудад хуваарилсан байдлыг авч үзвэл МАН 15%, АН 14%-тай байв. Үүний араас 13%-иар МНН, 8%-иар ИЗНН орсон бол Гурав дахь хүчин эвсэл, МУНН, ЭЧХН, ИХН адил 7%, Шударга ёс эвсэл, ЭОН тус бүр ижил 6%-ийг эзэлж, МСДН, ХХН, ЭОНН-уудад адил тэнцүү 3% оногджээ. Харин Бие даагчдын оргил цагт гарсан мэдээлэл хамгийн бага буюу 1%-ийг эзэлж байгаа юм. Үүнээс үзэхэд МҮОНТ Бие даагчдын талаар бусад нам, эвсэлтэй харьцуулахад оргил цагаараа маш бага мэдээлж байгаа нь харагдаж байна.

6. Судалгааны хугацаанд нэр дэвшигчдийг мэдээлсэн байдлыг хамгийн их хугацаа эзэлсэн байдлаар жагсаавал:

	Нэр дэвшигчид	Харъяалал	Нийт	Хувь
1	Б.Жаргалсайхан	Гурав дах хүчин эвсэл	00:19:05	14%
2	Б.Амарсанаа	МАН	00:17:36	13%
3	Б.Чулуунбат	МУНН	00:17:12	13%
4	Д.Эрдэнэбат	АН	00:17:10	13%
5	М.Энхболд	МАН	00:11:21	8%
6	С.Эрдэнэ	АН	00:10:49	8%
7	Я.Батсуурь	АН	00:10:43	8%
8	Н.Жамсран	ЭЧХН	00:10:33	8%
9	С.Ганбаатар	Бие даагч	00:10:15	8%
10	П.Давааням	МНН	00:09:42	7%

Эхний 10-т орсон нэр дэвшигчдийг эерэг болон төвийг сахисан байдлаар мэдээлж, сөрөг өнгө аястайгаар мэдээлээгүй. Нэр дэвшигчдийн мэдээллийн өнгө аясыг хувиар илэрхийлвэл:

	Нэр дэвшигчид	Харъяалал	Эерэг	Төвийг сахисан	Сөрөг
1		Гурав дах	15%	11%	0%

	Б.Жаргалсайхан	хүчин эвсэл			
2	Б.Амарсанаа	МАН	13%	15%	0%
3	Б.Чулуунбат	МУНН	14%	7%	0%
4	Д.Эрдэнэбат	АН	14%	6%	0%
5	М.Энхболд	МАН	3%	37%	0%
6	С.Эрдэнэ	АН	9%	5%	0%
7	Я.Батсуурь	АН	8%	7%	0%
8	Н.Жамсран	ЭЧХН	8%	5%	0%
9	С.Ганбаатар	Бие даагч	8%	6%	0%
10	П.Давааням	МНН	8%	1%	0%

**7.** МҮОНТ-ийн сонгуулийн сурталчилгаатай холбоотой нэвтрүүлгийг хэлбэрийн хувьд хуваарьт цаг 04:45:07, сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг 05:24:21, далд сурталчилгааны шинжийг агуулсан мэдээлэл 04:22:59 цагийг эзэлсэн байна. Эдгээрийг хувиар илэрхийлвэл хуваарьт нэвтрүүлэг 33%, сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг 37%, далд сурталчилгаа 30% байна. 1 дүгээр хэсгийн дүнтэй харьцуулахад хуваарьт цагийн эзлэх хувь буурч сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлгийн цаг 15%-иар, далд хэлбэрийн сурталчилгаа 12%-иар өссөн үзүүлэлт харагдаж байна.

**8.** МҮОНТ-ийн мэдээний хөтөлбөрт хийсэн шинжилгээгээр нийт 03:55:49 цагийн сонгуультай холбоотой мэдээлэл илэрсэн байна. Энэ нь нийт сонгуультай холбоотойгоор илэрсэн мэдээллийн 27%-ийг эзэлж байгаа юм. Энэ нь мөн өмнөхтэй харьцуулахад 10%-иар өссөн харагдаж байна.

Мэдээний хөтөлбөрт нам, эвсэл, бие даагчдын эзэлсэн хувь хэмжээг харьцуулан үзүүлвэл АН 21%, МАН 20%, МНН 10%-ийг эзэлжээ. Бусад намуудад ерөнхийдөө ойролцоо буюу 4-5%-тай тэнцэх хэмжээний цаг оногдсон байна. Харин Бие даагчдад зарцуулсан цаг нь мэдээний хөтөлбөрт эзэлсэн цагийн 3%-тай тэнцэж байгаа юм. Эндээс харахад сонгуульд нэр дэвшигч 14 субъект бүгд мэдээний хөтөлбөрт цаг эзэлсэн байна. Энэ нь өмнөхтэй харьцуулахад дэвшилттэй үзүүлэлт юм.

**9.** МҮОНТ-ээр далд сурталчилгааны шинжийг агуулсан мэдээлэл 04:22:59 байв. Далд сурталчилгааны цагийг МАН, АН хоёр ижилхэн 38%-тай эзэлжээ. Эндээс харахад МАН-ын далд сурталчилгаа 11%-иар буурч, АН-ынх 8%-иар өссөн үзүүлэлттэй харагдаж байна. Хоёр намын араас ИЗНН 7%, Шударга ёс эвсэл 4%, ИХН 3% эзэлжээ. ЭЧХН, Гурав дахь хүчин эвсэл-д адил 2% оногдсон бол ЭОН-ын далд сурталчилгааны цаг 1%-тай тэнцэв. МҮОНТ-ийн далд сурталчилгаа хэлбэрийн мэдээллийн 5% нь Бие даагчдын тухай мэдээлэл байсан нь судалгаагаар илэрсэн байна.

Далд сурталчилгааг агуулгаар нь ангилахад дийлэнхи нь нь буюу 88% нь А2 хэлбэрийн, 2% нь А1 хэлбэрийн, 10% нь Б хэлбэрийн мэдээлэл байв. Харин В хэлбэрийн мэдээлэл 5 секунд эзэлсэн нь 0%-тай гарчээ.

Далд сурталчилгааны А1 хэлбэрийн 76%-ийг МАН, 13%-ийг Шударга ёс эвсэл эвсэл, 11%-ийг АН тус тус эзэлжээ. Бие даагчид болон бусад нам, эвслийн талаар А1 хэлбэрийн далд сурталчилгаа илрээгүй байна.

Далд сурталчилгааны А2 хэлбэрт хамаарах мэдээллийн 43% нь АН-д, 32% нь МАН-д оногдсон бол Шударга ёс эвсэл, ИЗНН-д адилхан 5%, ИХН-д 4%, ЭЧХН-д 3%, Гурав дахь хүчин эвсэл-д 2% ЭОН-д 1% тус бүр ногджээ. Харин далд сурталчилгааны А2 хэлбэрт бие даагчид 5%-тай тэнцэх цагийг эзэлсэн байна. ХХН, МНН-ууд А2 хэлбэрийн далд сурталчилгаа явуулаагүй байна.

Далд сурталчилгааны Б хэлбэрт хамрагдах мэдээлэл 00:26:11 секундын мэдээлэл байв. Үүний 76% нь МАН-ын, 24% нь ИЗНН-ын мэдээлэл байв. Далд сурталчилгааны Б хэлбэр өмнөхтэй харьцуулахад өссөн нь харагдаж байна. 1 дүгээр хэсгийн дүнгээр ердөө л 1 мин 40 секундын эзэлж байсан юм.

МҮОНТ-ээр далд сурталчилгааны В хэлбэрт хамаарагдах мэдээлэл нийтдээ 5 секунд эзэлжээ. Энэ нь АН-ын мэдээлэл байсан хийгээд нийт дүнтэй харьцуулахад 0% гарч байна.

## **25-р суваг телевиз Мониторингийн 2-р хэсэг /6 дугаар сарын 12-19/**

1. Сурталчилгалгааны хугацаанд МН25-р суваг телевизийн 124:58:32 цагийн бичлэгт мониторинг хийснээс 17:56:58 цаг нь буюу 14% нь сонгуулийн сурталчилгаатай холбогдсон мэдээлэл байлаа. Тус телевиз сонгуулийн сурталчилгаанд зориулсан нэвтрүүлгийнхээ 49%-ийг МАН-д, 39%-ийг АН-д, 10%-ийг ИЗНН-д, 2%-ийг Шударга ёс эвсэл-д зориулжээ. ИХН, МНН-д зарцуулсан цаг нь 1%-д ч хүрээгүй байна. Бусад нам, эвслийн талаар огт мэдээлэл хүргээгүй байна. Харин Бие даагчдад ногдсон цаг нь ердөө 65 секунд юм. Өмнөх тайлантай харьцуулахад АН-д зарцуулах цаг нь багасч, эсрэгээрээ МАН-д зарцуулсан цаг нь нэмэгдсэн байна.

2. Сонгуулийн сурталчилгаатай холбоотойгоор хүргэсэн 17:56:58 цагийн нэвтрүүлгийн 11 минут 04 секунд нь л хараат бус, сонгогчдын боловсролд зориулсан агуулгатай мэдээлэл байв. Энэ нь нийт мэдээллийн 1%-тай тэнцэж байгаа юм. Эхний дүнтэй харьцуулахад бага зэрэг нэмэгдсэн хандлага ажиглагдаж байна.

3. Нийт мэдээллийн эх сурвалжийн байдлыг харгалзан үзвэл дийлэнх нь буюу 79% нь шууд эх сурвалжаас авсан, 21% нь шууд бус эх сурвалжийн мэдээлэл байна. Дүнгээс харахад шууд эх сурвалж ашигласан байдал нь өмнөх тайлангийн дүнтэй харьцуулахад 8%-иар буурсан байна.

4. 25-р суваг телевизээр цацагдсан сонгуультай холбоотой нийт мэдээллийн 68% нь төлбөртэй, захиалгатай гэж тэмдэглэснээс гадна, төлбөртэй шинжийг агуулсан мэдээлэл байв. Харин цаг үеийн мэдээний хөтөлбөрөөр гарсан сонгуулийн сурталчилгаатай холбоотой мэдээлэл нь нийт цагийн 13%-ийг эзлэв.

5. Мэдээллийн чанарын хувьд дийлэнх буюу 95% нь эерэг, 4% нь төвийг сахисан өнгө аястай мэдээлэл байв. Сөрөг аястай мэдээлэл 1%-ийг эзэлж байна. 1 дүгээр тайлантай харьцуулахад эерэг хандлага 2%-иар нэмэгдэж, төвийг сахисан мэдээлэл 2% буурсан үзүүлэлт гарчээ. Мөн сөрөг хандлагатай мэдээллийн эзлэх хувь 1%-д хүрсэн байна.

Эерэг өнгө аястай мэдээллийн 50% нь МАН-д, 37% нь АН-д, 11% нь ИЗНН, 2% нь Шударга ёс эвсэл-д ногдсон бол ИХН, МНН-ын талаарх эерэг хандлагатай мэдээлэл нь 1%-д ч хүрээгүй байна. Мөн Бие даагчдад багахан цаг оногдсон нь 1%-д хүрээгүй байна.

25-р суваг телевиз АН-ыг хамгийн их төвийг сахисан байдлаар мэдээлжээ. Энэ нь 80%-ийг эзэлж байна. Харин МАН-д, Шударга ёс эвсэл-д тус бүр 6% оногдсон бол ИЗНН-ын төвийг сахисан мэдээлэл 2%-ийг эзэлжээ. Бусад нам, эвсэл, бие даагчдын талаар төвийг сахисан байдлаар мэдээлээгүй байна.

Сөрөг сурталчилгаанд нийт 13 минут 22 секундыг зарцуулсан байсны 80% нь МАН-д, үлдсэн 20% нь ИХН-д оногдсон байна.

6. Сонгуулийн сурталчилгаатай холбоотой нэвтрүүлгийн 89%-ийг оргил цагт, 21%-ийг энгийн цагт зарцуулжээ. Энэ нь 25-р суваг телевиз сонгуультай холбоотой мэдээгээ оргил цагт түлхүү гаргах болсон нь харагдаж байна.

Оргил цагийн нэвтрүүлгийн 50% нь МАН-д, 41% нь АН-д, 7% нь ИЗНН-д, 2%-нь Шударга ёс эвсэлд оногджээ. Бусад нам, эвсэл болон бие даагчдад оногдсон цаг нь 1%-д ч хүрээгүй байна.

7. Судалгааны хугацаанд нэр дэвшигчдийн хугацаа эзэлсэн байдлыг мэдээлсэн байдлыг эхний 10-р жагсаавал:

	<b>Нэр дэвшигчид</b>	<b>Харъяалал</b>	<b>Нийт</b>	<b>Хувь</b>
1	З.Алтай	ИЗНН	01:20:05	20%
2	М.Энх-Амгалан	МАН	01:17:10	19%
3	Б.Лхагважав	МАН	00:45:06	11%
4	Г.Батхүү	АН	00:41:03	10%
5	Ё.Отгонбаяр	МАН	00:38:25	10%
6	Л.Гантөмөр	АН	00:25:30	7%
7	Г.Тэнгэр	МАН	00:25:30	7%
8	Ц.Дашдорж	МАН	00:23:58	6%
9	О.Содбилэг	МАН	00:21:30	5%
10	М.Энхболд	МАН	00:20:14	5%

Дээрх Эхний-10 жагсаалтад орсон нэр дэвшигчдийг эерэг болон төвийг сахисан хандлагаар мэдээлжээ. Нэр дэвшигчдийн мэдээллийн өнгө аясыг хувиар илэрхийлвэл:

	<b>Нэр дэвшигчид</b>	<b>Харъяалал</b>	<b>Эерэг</b>	<b>Төвийг сахисан</b>	<b>Сөрөг</b>
1	З.Алтай	ИЗНН	99%	1%	0%
2	М.Энх-Амгалан	МАН	100%	0%	0%
3	Б.Лхагважав	МАН	100%	0%	0%

4	Г.Батхүү	АН	100%	0%	0%
5	Ё.Отгонбаяр	МАН	100%	0%	0%
6	Л.Гантөмөр	АН	100%	0%	0%
7	Г.Тэнгэр	МАН	100%	0%	0%
8	Ц.Дашдорж	МАН	100%	0%	0%
9	О.Содбилэг	МАН	100%	0%	0%
10	М.Энхболд	МАН	97%	3%	0%

Хүснэгтээс харахад 25-р суваг телевиз нэр дэвшигчдийг магтаж, сайшаасан байдалтайгаар мэдээлжээ.

**8.** 25-р суваг телевизийн сонгуулийн сурталчилгаанд зориулсан нэвтрүүлгийг хэлбэрийн хувьд ангилан үзвэл төлбөртэй буюу төлбөртэй шинж агуулсан мэдээлэл 12:10:57, сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэл 0:11:04, далд сурталчилгааны шинжийг агуулсан мэдээлэл 05:34:57 цагийг эзэлжээ. Үүнийг хувиар илэрхийлвэл төлбөртэй сурталчилгаа 68%, сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг 1%, далд сурталчилгаа 31% байна. 1 дүгээр шатны дүнтэй харьцуулахад төлбөртэй сурталчилгааны цаг нэмэгдэж, далд сурталчилгаа буурсан хандлагатай байна. Харин сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлгийн хэмжээ 6 минут 40 секундээр нэмэгдсэн боловч 1% эзэлсэн хэвээрээ байна.

- Тус телевизийн төлбөртэй нэвтрүүлэг цацсан цагийг судалгаанд хамрагдсан 8 өдөрт харьцуулан дунджаар илэрхийлвэл 01:31:22 секунд гарч байна. Энэ нь 25-р суваг телевизийн төлбөртэй нэвтрүүлгийн хугацаа хуулинд заасан 2 цагийг хэтрүүлээгүй мэт харагдаж байгаа боловч далд хэлбэрийн сурталчилгааны цагийг нь тооцон үзвэл өөр дүн гарч байна.

- Далд сурталчилгаа, төлбөртэй сурталчилгаа хоёрын цагийг нийлүүлэн 6 өдөрт хуваан дунджаар илэрхийлвэл 2:13:14 цаг нэг өдөрт ногдож байна.

**9.** Далд сурталчилгааны 52%-ийг МАН эзэлсэн бол АН 27%, ИЗНН 16%, Шударга ёс эвсэл 4%, МНН 1%-ийг тус тус эзэлжээ. Харин бусад нам, эвсэл болон Бие даагчдын талаар далд хэлбэрийн сурталчилгаа цацаагүй байна.

- Далд сурталчилгааг мэдээллийн агуулгаар нь А, Б, В гэж гурав ангилсан. Үүний дотор А ангиллыг мөн 1, 2 хэсэгт ангилан үзсэн. Тус телевизийн далд сурталчилгаа явуулсан цагийг агуулгаар нь ангилвал дийлэнх нь буюу 65% нь Б хэлбэрт, 28% нь А2 хэлбэрт хамаарагдаж үлдсэн 7% нь А1 шинжийг тус тус агуулжээ. Нийт 29 секундын В хэлбэрийн далд сурталчилгаа илэрсэн нь 1%-д хүрээгүй байна.

- Далд сурталчилгааны А1 хэлбэрийн 00:24:28 цагийн мэдээлэл цацагдсанаас 59%-ийг МАН-ын мэдээлэл эзэлсэн нь хамгийн өндөр байна. Шударга ёс эвсэл 23%, АН 18%-ийг тус тус эзэлжээ. Үлдсэн бусад намын талаар А1 хэлбэрийн далд сурталчилгаа цацаагүй байна.

А2 хэлбэрийн далд сурталчилгаа 01:31:57 цаг илэрсний дийлэнх буюу 64%-ийг МАН дангаараа эзэлсэн байна. АН 24%-ийг эзэлсэн бол буурсаар Шударга ёс эвсэл 5%, ИЗНН 4%, МНН 3%-ийг эзэлсэн дүн гарчээ.

Далд сурталчилгааны хамгийн их цагийг Б хэлбэрийн далд сурталчилгаа эзэлсэн нь 03:38:03 байв. Үүний 46% нь МАН-ын мэдээлэл байв. Харин АН 29%, ИЗНН 24%-ийг эзэлсэн бол үлдсэн 1% нь Шударга ёс эвсэл-ийн мэдээлэл байв.

**10.** 25-р суваг телевизийн мэдээний хөтөлбөрт шинжилгээ хийхэд 02:17:06 цагийн мэдээлэл нь сонгуультай холбоотой байв.

Цаг үеийн шинжтэй мэдээний хөтөлбөрөөр намуудыг хэрхэн мэдээлсэн талаар шинжлэхэд 5 намын талаар л мэдээлсэн нь илрэв. Үүнээс МАН 64%, АН 20%, Шударга ёс эвсэл 9%, ИЗНН-д 7%, МНН 2%-ийг тус тус эзэлжээ. Бусад нам, эвсэл болон Бие даагчдын талаар мэдээний хөтөлбөрөөр мэдээлээгүй байна.

Мэдээний хөтөлбөрөөр цацагдсан сонгуультай холбоотой мэдээллийн 87% нь эерэг, 7% нь сөрөг, 6% нь төвийг сахисан өнгө аястай байв.

### **“TV9” телевиз** **Мониторингийн 2-р хэсэг** /6 дугаар сарын 12-19/

**1.** Сурталчилгааны хугацаанд “TV9” телевизийн 148:14:36 цагийн бичлэгт мониторинг хийснээс 33:31:50 цаг нь буюу 23% нь сонгуулийн сурталчилгаатай холбогдсон мэдээлэл байлаа. Эхний тайлантай харьцуулахад сонгуульд зориулсан хугацаа 2 дахин нэмэгджээ.

Тус телевиз сонгуулийн сурталчилгаанд зориулсан нэвтрүүлгийнхээ 35%-ийг буюу 11:25:22 цагийг дангаар нь Шударга ёс эвсэл-д, 32%-ийг АН-д, 19%-ийг МАН-д, 5%-ийг ИЗНН-д зарцуулж, ЭОНН, ЭОН-уудад адилхан 2%, МНН, ИХН-уудад адил тэнцүү 1% тус тус зарцуулжээ. Харин Бие даагчдын мэдээлэл 3%-ийг эзэлсэн байна.

**2.** Сонгуулийн сурталчилгаатай холбоотойгоор 16:14:25 цагийн нэвтрүүлэг цацсанаас 01:08:19 секунд нь хараат бус, сонгогчдын боловсролд зориулсан агуулгатай мэдээлэл байв. Энэ нь нийт мэдээллийн 4%-д хүрч байгаа юм. Эхний шатны дүнтэй харьцуулахад сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлгийн хэмжээ өссөн болох нь харагдаж байна.

**3.** Нийт мэдээллийн эх сурвалж ашигласан байдлыг харгалзан үзвэл 52% нь шууд бус, 48% нь шууд эх сурвалжийн мэдээлэл байна. Бусад телевизүүдтэй харьцуулахад шууд эх сурвалж ашигласан байдал нь бага байна.

**4.** “TV9” телевизээр цацагдсан сонгуулийн сурталчилгаатай холбогдсон нийт мэдээллийн 33% нь төлбөртэй, захиалгатай гэж тэмдэглэсэн нэвтрүүлэг байв. Харин цаг үеийн мэдээний хөтөлбөрөөр гарсан сонгуулийн сурталчилгаатай холбоотой мэдээлэл нь нийт цагийн 21%-ийг эзлэв.

**5.** Мэдээллийн чанарын хувьд дийлэнх буюу 67% нь эерэг, 26% нь төвийг сахисан өнгө аястай мэдээлэл байв. Сөрөг өнгө аястай мэдээлэл 7%-ийг эзэлжээ.

Эерэг өнгө аястай мэдээллийн 35% нь Шударга ёс эвсэл-д, 31% нь АН-д, 21% нь МАН-д зарцуулсан бол ИЗНН, ЭОН-д адилхан 3%, ЭОНН-д 2%, ИХН-д 1% тус тус оногджээ. Эерэг мэдээллийн 4%-ийг Бие даагчид эзэлсэн байна.

“TV9” телевизийн төвийг сахисан мэдээллийн хамгийн их цагийг Шударга ёс эвсэл 44%-иар эзэлжээ. Түүний дараа АН 33%-тай байна. ИЗНН-ын төвийг сахисан мэдээлэл 11%,



МАН 5%, МНН 3%, ЭОН 1%-ийг эзэлсэн байна. Бусад нам, эвслийн талаар төвийг сахисан байдлаар мэдээлээгүй байна. Харин бие даагчид 3%-ийг эзэлжээ.

Сөрөг сурталчилгаанд нийт 02:15:38 цаг зарцуулсны 63%-нь МАН-ын тухай, 37% нь АН-д ногджээ. Бусад нам, эвсэл болон бие даагчдын талаар сөрөг хандлагатай мэдээлэл илрээгүй байна.

6. Сонгуулийн сурталчилгаатай холбоотой нэвтрүүлгийн 59%-ийг оргил цагт, 41%-ийг энгийн цагт зарцуулжээ.

Оргил цагийн нэвтрүүлгийн 34%-ийг Шударга ёс эвсэл, 25%-ийг АН, 23%-ийг МАН, 7%-ийг-ИЗНН, 3%-ийг ЭОНН, 2%-ийг ЭОН, 1%-ийг ИХН эзэлсэн бол Бие даагчдад 4% оногдсон байна. TV9 телевизийн Гурав дахь хүчин эвсэл-ийг оргил цагаараа мэдээлсэн байдал нь нийт оргил цагийн 1%- ч хүрэхгүй байна.

7. Судалгааны хугацаанд нэр дэвшигчдийг мэдээлсэн байдлыг эхний 10-р жагсаавал:

	Нэр дэвшигчид	Харъяалал	Нийт	Хувь
1	Б.Тулга	Шударга ёс эвсэл	02:00:09	27%
2	Га.Баярсайхан	АН	00:41:57	9%
3	Д.Ганхуяг	АН	00:40:12	9%
4	М.Зоригт	АН	00:33:57	9%
5	Л.Энх-Амгалан	МАН	00:36:52	8%
6	Х.Амарсайхан	Шударга ёс эвсэл	00:36:02	8%
7	Б.Батбаатар	АН	00:34:42	8%
8	Л.Эрдэнэчимэг	АН	00:33:08	8%
9	Д.Бат-Эрдэнэ	АН	00:33:03	7%
10	Б.Ариунсан	АН	00:31:48	7%

Дээрх Эхний-10 жагсаалтад орсон нэр дэвшигчдийг эерэг болон төвийг сахисан хандлагаар мэдээлжээ. Нэр дэвшигчдийн мэдээллийн өнгө аясыг хувиар илэрхийлвэл:

	Нэр дэвшигчид	Харъяалал	Эерэг	Төвийг сахисан	Сөрөг
1	Б.Тулга	Шударга ёс эвсэл	53%	47%	0%
2	Га.Баярсайхан	АН	92%	8%	0%
3	Д.Ганхуяг	АН	54%	46%	0%
4	М.Зоригт	АН	96%	4%	0%

5	Л.Энх-Амгалан	МАН	97%	3%	0%
6	Х.Амарсайхан	Шударга ёс эвсэл	60%	40%	0%
7	Б.Батбаатар	АН	60%	40%	0%
8	Л.Эрдэнэчимэг	АН	43%	57%	0%
9	Д.Бат-Эрдэнэ	АН	0%	100%	0%
10	Б.Ариунсан	АН	100%	0%	0%

**8.** “TV9” телевизийн сонгуулийн сурталчилгаанд зориулсан нэвтрүүлгийг хэлбэрийн хувьд ангилан үзвэл төлбөртэй буюу төлбөртэй шинж агуулсан мэдээлэл 24:12:58, сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэл 01:08:19, далд сурталчилгааны шинжийг агуулсан мэдээлэл 08:10:33 цагийг эзэлжээ. Эдгээрийг хувьчлан илэрхийлвэл төлбөртэй сурталчилгаа 72%, далд сурталчилгаа 24% эзэлж харин сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэл дөнгөж 4%-ийг эзэлж байгаа юм. Гэвч сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлгийн цаг нэмэгдсэн байна.

Энэ телевизийн төлбөртэй нэвтрүүлэг цацсан цагийг судалгаанд хамрагдсан 8 өдөрт харьцуулан дунджаар илэрхийлвэл 03:01:37 цаг гарч байна. Эндээс харахад 1 цаг 01 минут 30 секундээр хэтэрсэн байна.

Далд сурталчилгаа, төлбөртэй сурталчилгаа хоёрын цагийг нийлүүлэн 8 өдөрт хуваан дунджаар илэрхийлвэл 04:02:56 цаг нэг өдөрт ногдож байна.

**9.** TV9 телевизээр нийт 08:10:33 цагийн далд сурталчилгааны хэлбэртэй мэдээлэл цацсанаас 40% нь дангаараа Шударга ёс эвслийн тухай мэдээлэл байв. Харин МАН 28%-ийг, АН 21%-ийг, ЭОН 4%-ийг, МНН 3%-ийг эзэлсэн бол ИЗНН, Гурав дахь хүчин эвсэлд тус бүр 1% оногдсон байна. Бие даагчид далд сурталчилгааны 2%-ийг эзлэж байна.

Далд сурталчилгааг мэдээллийн агуулгаар нь А, Б, В гэж гурав ангилсан. Үүний дотор А ангиллыг мөн 1, 2 хэсэгт ангилан үзсэн. Тус телевизийн далд сурталчилгаа явуулсан цагийг агуулгаар нь ангилвал 67% нь А2, 27% нь Б хэлбэрийн далд сурталчилгаа байсан бол А2 болон В хэлбэрийн далд сурталчилгаа 4%-ийг эзэлжээ. Энд А1 хэлбэрийн сурталчилгаа хамгийн бага буюу 2%-ийг эзэлсэн байна.

Далд сурталчилгааны А1 хэлбэрийн 39%-ийг МАН эзэлсэн бол АН, МНН адилхан 21%-ийг эзэлж үлдсэн 19% нь ИЗНН-ын тухай мэдээлэл байв. Бусад нам эвсэл болон бие даагчдын талаар А1 хэлбэрийн далд сурталчилгаа илрээгүй байна.

А2 хэлбэрийн далд сурталчилгаа хамгийн их цагийг эзэлсэн юм. Үүнийг нам тус бүрээр танилцуулвал Шударга ёс эвсэл-д 48%, МАН-д 20%, АН-д 19%, ЭОН-д 5%, МНН-д 3%, Гурав дахь хүчин эвсэл-д 1% тус тус оногджээ. Харин Бие даагчид А2 хэлбэрийн далд сурталчилгааны 4%-ийг эзэлсэн байна.

Б хэлбэрийн далд сурталчилгаа нь 4 субъектэд хамааралтай байна. Энд 41%-ийг МАН-ын тухай мэдээлэл эзэлжээ. Харин АН-д 30%, Шударга ёс эвсэл-д 26%, ЭОН-д 3%-ын Б хэлбэрийн далд сурталчилгааны цаг оногдсон байна.

В хэлбэрийн далд сурталчилгааны 83%-ийг АН, 17%-ийг Шударга ёс эвсэл эзэлж байна. Бусад нам, эвсэл, бие даагчдын талаар В хэлбэрийн сурталчилгаа гараагүй байна.

**10.** TV9 телевизийн цаг үеийн мэдээний хөтөлбөрт шинжилгээ хийхэд 07:17:27 цагийн мэдээлэл нь сонгуультай холбоотой байв.

Цаг үеийн шинжтэй мэдээний хөтөлбөрөөр намуудыг хэрхэн мэдээлсэн талаар шинжлэхэд Шударга ёс эвсэл 43%-ийг эзэлсэн байв. Түүний дараа МАН 25%, АН 21%, МНН, ЭОН-ууд адил 3%-ийг, Гурав дахь хүчин эвсэл, ИЗНН-ууд ижилхэн 1%-тай тэнцэх цаг оногдсон байна. Тус телевизийн мэдээний хөтөлбөрөөр Бие даагчдын талаар мэдээлсэн байдал нь 3%-д хүрч байна.

Мэдээний хөтөлбөрөөр цацагдсан сонгуультай холбоотой мэдээллийн 48% нь тухайн нам эвсэл, бие даагчдыг эерэгээр харуулсан, 33% нь төвийг сахисан, 19% нь сөрөг хандлагатайгаар мэдээлсэн байна. Эндээс дүгнэхэд эерэг болон төвийг сахисан хандлагатай мэдээллийн хэмжээ буурч сөрөг хандлага нэмэгджээ.

**“UBS” телевиз**  
**Мониторингийн 2-р хэсэг**  
/6 дугаар сарын 12-19/

**1.** Сурталчилгааны хугацаанд “UBS” телевизийн 143:30:42 цагийн бичлэгт мониторинг хийснээс 18:23:45 цаг нь буюу 13% нь сонгуулийн сурталчилгаатай холбогдсон мэдээлэл байлаа.

Тус телевиз энэ хугацаанд сонгуулийн сурталчилгаанд зориулсан нэвтрүүлгийнхээ 47%-ийг МАН-д, 41%-ийг АН-д зориулсан бол Шударга ёс эвсэл, ИХН, ИЗНН-уудад адилхан 3%, Гурав дахь хүчин эвсэл-д 2%-ийг тус тус оноожээ. ЭОН-ын талаар 11 минут 35 секундын мэдээлэл цацсан боловч энэ нь 1%-д ч хүрээгүй байна. Бусад нам болон Бие даагчдын талаар мэдээлээгүй байна.

**2.** Сонгуулийн сурталчилгаатай холбоотойгоор 18:23:45 цагийн нэвтрүүлэг цацсанаас 00:23:45 цаг нь сонгогчдын боловсролд зориулсан агуулгатай мэдээлэл байна. Энэ нь нийт мэдээллийн 2%-ийг эзэлж байна. Эхний шатны дүнтэй харьцуулахад сонгогчдын боловсролд цаг зарцуулсан нь харагдаж байна. Учир нь өмнө нь огт мэдээлэл байгаагүй юм.

**3.** Нийт мэдээллийн эх сурвалж ашигласан байдлыг харгалзан үзвэл 63% нь шууд эх сурвалжаас авсан, 37% нь шууд бус эх сурвалжийн мэдээлэл байна.

**4.** “UBS” телевизээр цацагдсан сонгуулийн сурталчилгаатай холбогдсон нийт мэдээллийн 37% нь төлбөртэй, захиалгатай гэдэг нь илт тодорхой нэвтрүүлэг байв. Харин цаг үеийн мэдээний хөтөлбөрөөр гарсан сонгуулийн сурталчилгаатай холбоотой мэдээлэл 39 секунд гарч өмнөх дүнгээс буурсан хандлага ажиглагдаж байна.

5. Мэдээллийн чанарын хувьд дийлэнх буюу 99% нь эерэг, 1% нь сөрөг өнгө аястай мэдээлэл байв. Төвийг сахисан байдлаар мэдээлэл цацаагүй байна. Учир нь тус телевизийн сонгуулийн сурталчилгаатай холбоотой мэдээллийн дийлэнх нь намын захиалгат нэвтрүүлэг болон реклам эзэлж байгаа юм.

Эерэг өнгө аястай мэдээллийн 48% нь МАН-д, 41% нь АН-д оногдсон бол ИХН, ИЗНН-д адил 3%, Гурав дахь хүчин эвсэл, Шударга ёс эвсэлд адил 2% тус бүр ногдож үлдсэн 1% нь ЭОН-ын тухай мэдээлэл байв. Бусад нам, бие даагчдын талаар эерэг өнгө аясаар мэдээлээгүй байна.

Тус телевизээр 5 секундын төвийг сахисан мэдээлэл гарсан нь МАН-ын тухай байв.

“UBS” телевизээр 9 минут 29 секундын мэдээлэл цацагджээ. Үүний 74% нь АН, 24% нь МАН, 2% нь Шударга ёс эвслийн мэдээлэл байв.

6. Сонгуулийн сурталчилгаатай холбоотой нэвтрүүлгийн 84%-ийг оргил цагт, 16%-ийг энгийн цагт зарцуулжээ.

Оргил цагийн нэвтрүүлгийн 48%-ийг МАН, 41%-ийг АН, 4%-ийг ИХН, 3%-ийг ИЗНН-ын мэдээлэл эзэлсэн бол Гурав дахь хүчин эвсэлд 2%, Шударга ёс эвсэл, ЭОН-д 1% тус тус оногджээ. Энд дурьдсанаас бусад нам болон Бие даагчдын талаар оргил цагт мэдээлэл цацаагүй байна.

7. Судалгааны хугацаанд нэр дэвшигчдийг мэдээлсэн байдлыг эхний 10-р жагсаавал:

	Нэр дэвшигчид	Харъяалал	Нийт	Хувь
1	Ё.Отгонбаяр	МАН	00:43:14	14%
2	Г.Занданшатар	МАН	00:34:56	11%
3	Л.Амгалан	МАН	00:33:47	11%
4	Д.Сүхжаргалмаа	ИХН	00:31:04	10%
5	Га.Баярсайхан	АН	00:29:42	10%
6	Б.Ариансан	АН	00:29:30	10%
7	Ч.Ганхуяг	МАН	00:27:30	9%
8	Д.Зоригт	МАН	00:26:47	9%
9	С.Одонтуяа	АН	00:25:45	8%
10	Д.Сумъяабазар	МАН	00:24:09	8%

Дээрх ТОП-10 жагсаалтад орсон нэр дэвшигчдийг 100% эерэг өнгө аястайгаар мэдээлжээ.

	Нэр дэвшигчид	Харъяалал	Эерэг	Төвийг сахисан	Сөрөг
1	Ё.Отгонбаяр	МАН	100%	0%	0%
2	Г.Занданшатар	МАН	100%	0%	0%
3	Л.Амгалан	МАН	100%	0%	0%
4	Д.Сүхжаргалмаа	ИХН	100%	0%	0%
5	Га.Баярсайхан	АН	100%	0%	0%
6	Б.Ариансан	АН	100%	0%	0%

7	Ч.Ганхуяг	МАН	100%	0%	0%
8	Д.Зоригт	МАН	100%	0%	0%
9	С.Одонтуяа	АН	100%	0%	0%
10	Д.Сумъяабазар	МАН	100%	0%	0%

8. “UBS” телевизийн сонгуулийн сурталчилгаанд зориулсан нэвтрүүлгийг хэлбэрийн хувьд ангилан үзвэл төлбөртэй буюу төлбөртэй шинж агуулсан мэдээлэл 16:29:02, далд сурталчилгааны шинжийг агуулсан мэдээлэл 01:30:58, сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг 00:23:45 цагийг эзэлжээ. Эдгээрийг хувьчлан илэрхийлвэл төлбөртэй сурталчилгаа 90%, далд сурталчилгаа 8%, сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг 2%-ийг эзэлж байна. Тус телевизийн хувьд өмнөх шаттай харьцуулахад далд сурталчилгааны хэмжээ буурч, сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг хүргэсэн нь харагдаж байна.

Энэ телевизийн төлбөртэй нэвтрүүлэг цацсан цагийг судалгаанд хамрагдсан 8 өдөрт харьцуулан дунджаар илэрхийлвэл 02:03:37 цаг гарч байна.

Далд сурталчилгаа, төлбөртэй сурталчилгаа хоёрын цагийг нийлүүлэн 8 өдөрт хуваан дунджаар илэрхийлвэл 02:15:00 цаг нэг өдөрт ногдож байна. Эндээс харахад “UBS” телевизийн сурталчилгаа хуулиар зөвшөөрөгдсөн 2 цагаасаа 15 минутаар хэтэрсэн нь харагдаж байна.

9. “UBS” телевизээр нийт 01:30:58 цагийн далд сурталчилгааны хэлбэртэй мэдээлэл цацсанаас 55% нь МАН-ын, 45% нь АН-ын тухай мэдээлэл байв. Харин бусад нам, эвсэл болон бие даагчдын талаар далд сурталчилгааны шинжтэй мэдээлэл цацагдаагүй байна.

Далд сурталчилгааг мэдээллийн агуулгаар нь А, Б, В гэж гурав ангилсан. Үүний дотор А ангиллыг мөн 1, 2 хэсэгт ангилан үзсэн. Тус телевизийн далд сурталчилгаа явуулсан цагийг агуулгаар нь ангилвал 1% нь А1, 99% нь Б хэлбэрийн далд сурталчилгаа байв.

А1 хэлбэрийн далд сурталчилгаа 39 секунд байсан нь МАН-ын тухай мэдээлэл байв.

Б хэлбэрийн далд сурталчилгааны цагийн 55%-ийг МАН, 45%-ийг АН эзэлжээ.

10. “UBS” телевизийн цаг үеийн мэдээний хөтөлбөрт шинжилгээ хийхэд 39 секундын мэдээлэл нь МАН-ын тухай мэдээ байв. Энэ нь эерэг болон төвийг сахисан өнгө аясаар мэдээлэгджээ.

### **“TV5” телевиз** **Мониторингийн 2-р хэсэг** /6 дугаар сарын 12-19/

1. Сурталчилгааны хугацаанд “TV5” телевизийн 153:49:27 цагийн бичлэгт мониторинг хийснээс 18:30:24 цаг нь буюу 12% нь сонгуулийн сурталчилгаатай холбогдсон мэдээлэл байлаа. Тус телевиз сонгуулийн сурталчилгаанд зориулсан нэвтрүүлгийнхээ 56%-ийг МАН-д, 22%-ийг АН-д, 17%-ийг ИЗНН-д, 3%-ийг Шударга ёс эвсэл-д зориулжээ. Харин бие даагчдад 2%-тай тэнцэх цаг оногджээ. Харин бусад нам эвслийн талаар ямар ч мэдээлэл хүргээгүй байна.

2. Сонгуулийн сурталчилгаатай холбоотойгоор хүргэсэн 18:30:24 цагийн нэвтрүүлгийн 01:13:30 секунд нь хараат бус, сонгогчдын боловсролд зориулсан агуулгатай мэдээлэл байв. Энэ нь нийт мэдээллийн 7%-д ч хүрэхгүй байна. Эхний шатны дүнтэй харьцуулахад 6%-иар өссөн хандлага ажиглагдаж байна.

3. Нийт мэдээллийн эх сурвалжийн байдлыг харгалзан үзвэл дийлэнх нь буюу 42% нь шууд эх сурвалжаас авсан, 58% нь шууд бус эх сурвалжийн мэдээлэл байна. TV5 телевизийн эх сурвалжийн байдлыг бусад телевизтэй харьцуулахад шууд бусаар мэдээлэх хувь нь өндөр байна. Шууд эх сурвалжийн хэмжээ өмнөх шатнаас 9%-иар буурсан болох нь ажиглагдаж байна.

4. “TV5” телевизээр цацагдсан сонгуулийн сурталчилгаатай холбогдсон нийт мэдээллийн 42% нь төлбөртэй, захиалгатай гэдэг нь илт танигдаж байв. Харин цаг үеийн мэдээний хөтөлбөрөөр гарсан сонгуулийн сурталчилгаатай холбоотой мэдээлэл нь нийт цагийн 23%-ийг эзлэв. Эндээс дүгнэхэд захиалгат нэвтрүүлгийн цаг буурч, харин мэдээллийн хөтөлбөрт эзлэх хэмжээ нь 8%-иар өссөн байна.

5. Мэдээллийн чанарын хувьд 60% нь эерэг өнгө аястай, 36% нь төвийг сахисан өнгө аястай, 4% нь сөрөг мэдээлэл байв. TV5 телевизийн хувьд эхний шатанд төвийг сахисан мэдээлэл нь бусад телевизүүдтэй харьцуулахад өндөр байсан боловч энэ удаад эерэг хандлага давамгайлсан байна.

Эерэг өнгө аястай мэдээллийн талаас илүү буюу 69% нь МАН-д, 19% нь АН-д, 9% нь ИЗНН-д тус тус оногджээ. Бусад нам, эвслийн талаар эерэг аястай мэдээлэл цацаагүй байна. Харин бие даагчид эерэг мэдээллийн 3%-ийг эзэлсэн байна.

TV5 телевиз МАН-ыг хамгийн их төвийг сахисан байдлаар мэдээлжээ. Энэ нь 41%-ийг эзэлж байна. Харин ИЗНН-д 31%, АН-д 19%, Шударга ёс эвсэл-д 9% тус тус ногджээ. Бусад нам, эвсэл, бие даагчдын талаар төвийг сахисан байдлаар мэдээлээгүй байна.

TV5 телевизийн сөрөг аястай мэдээлэл өсч 41 минут 56 секундэд хүрчээ. Үүний 86% нь дангаараа АН-ын тухай мэдээлэл байв. Харин сөрөг мэдээллийн 8%-ийг МАН, 6%-ийг Шударга ёс эвсэл тус тус эзэлжээ. Бусад нам, эвсэл болон Бие даагчдын талаар сөрөг мэдээлэл цацаагүй байна.

6. Сонгуулийн сурталчилгаатай холбоотой нэвтрүүлгийн 71%-ийг оргил цагт, 29%-ийг энгийн цагт цацжээ.

Оргил цагийн нэвтрүүлгийн 55%-ийг МАН, 28%-ийг АН, 14%-ийг ИЗНН, 1%-ийг Шударга ёс эвсэл тус тус эзэлжээ. Харин Бие даагчдын талаар нийт 18 минут 19 секундын мэдээлэл хүргэсэн нь бүхэлдээ оргил цагт цацагдаж энэ нь 2%-ийг эзэлсэн байна.

7. Судалгааны хугацаанд нэр дэвшигчдийг мэдээлсэн байдлыг эхний 10-р жагсаавал:

	<b>Нэр дэвшигчид</b>	<b>Харъяалал</b>	<b>Нийт</b>	<b>Хувь</b>
1	Т.Наранцэцэг	ИЗНН	00:55:00	16%
2	Ж.Мөнхбат	МАН	00:52:03	15%
3	Ё.Отгонбаяр	МАН	00:45:16	13%

4	М.Энхболд	МАН	00:33:49	10%
5	Л.Энх-Амгалан	МАН	00:30:50	9%
6	Ц.Дашдорж	МАН	00:28:45	8%
7	Б.Ариунсан	АН	00:27:40	8%
8	Г.Занданшатар	МАН	00:26:02	8%
9	Э.Сугар	ИЗНН	00:23:15	7%
10	М.Хүдэрбаатар	АН	00:21:59	6%

Дээрх жагсаалтад орсон нэр дэвшигчдийг эерэг болон төвийг сахисан хандлагаар мэдээлсэн бөгөөд сөрөг хандлагатай мэдээлэл нэвтрүүлгээгүй байна. Нэр дэвшигчдийн мэдээллийн өнгө аясыг хувиар илэрхийлвэл:

	<b>Нэр дэвшигчид</b>	<b>Харъяалал</b>	<b>Эерэг</b>	<b>Төвийг сахисан</b>	<b>Сөрөг</b>
1	Т.Наранцэцэг	ИЗНН	0%	100%	0%
2	Ж.Мөнхбат	МАН	26%	74%	0%
3	Ё.Отгонбаяр	МАН	89%	11%	0%
4	М.Энхболд	МАН	95%	5%	0%
5	Л.Энх-Амгалан	МАН	100%	0%	0%
6	Ц.Дашдорж	МАН	100%	0%	0%
7	Б.Ариунсан	АН	86%	14%	0%
8	Г.Занданшатар	МАН	100%	0%	0%
9	Э.Сугар	ИЗНН	22%	78%	0%
10	М.Хүдэрбаатар	АН	97%	3%	0%

8. “TV5” телевизийн сонгуулийн сурталчилгаанд зориулсан нэвтрүүлгийг хэлбэрийн хувьд ангилан үзвэл төлбөртэй буюу төлбөртэй шинж агуулсан мэдээлэл 12:23:10, далд сурталчилгааны шинжийг агуулсан мэдээлэл 04:53:44 цаг, сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг 01:13:30 цагийг эзэлжээ. Үүнийг хувиар илэрхийлвэл төлбөртэй сурталчилгаа 67%, далд сурталчилгаа 26% байна. Сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг 7%-ийг эзэлжээ. Эхний шатны дүнтэй харьцуулахад төлбөртэй буюу төлбөртэй шинжийг агуулсан нэвтрүүлгийн цаг багасаж сонгогчдын боловсролд зориулсан цаг нэмэгдсэн байна.

- Тус телевизийн төлбөртэй нэвтрүүлэг цацсан цагийг судалгаанд хамрагдсан 8 өдөрт харьцуулан дунджаар илэрхийлвэл 01:32:53 секунд гарч байна. Энэ нь TV5 телевизийн төлбөртэй нэвтрүүлгийн хугацаа хуулинд заасан 2 цагийг хэтрүүлээгүй нь харагдаж байна.

- Далд сурталчилгаа, төлбөртэй сурталчилгаа хоёрын цагийг нийлүүлэн 8 өдөрт хуваан дунджаар илэрхийлвэл 02:09:36 цаг нэг өдөрт ногдож байна.

**9.** Далд сурталчилгааны 40%-нь МАН-д, 32% нь ИЗНН-д, 16% нь АН-д, Шударга ёс эвсэл-д 12% оногджээ.

- Далд сурталчилгааг мэдээллийн агуулгаар нь А, Б, В гэж гурав ангилсан. Үүний дотор А ангиллыг мөн 1, 2 хэсэгт ангилан үзсэн. Тус телевизийн далд сурталчилгаа явуулсан цагийг агуулгаар нь ангилвал 7% нь А1, 51% нь А2, 33% нь Б хэлбэрт, 9% нь В хэлбэрт хамаарагдаж байна.

Далд сурталчилгааны А1 хэлбэрийн 83%-нь МАН-д, 17% нь АН-ын тухай мэдээлэл байв. Бусад нам эвсэл, Бие даагчдын талаар А1 хэлбэрийн далд сурталчилгаа явуулаагүй байна.

- Далд сурталчилгааны А2 хэлбэрийн мэдээллийн 61% нь ИЗНН, 23% нь Шударга ёс эвсэл 11% нь МАН-д тус тус оногдож байна. Үлдсэн 1%-нь Бие даагчид эзэлжээ.

- Б хэлбэрийн далд сурталчилгаа нь үндсэндээ 4 субъектийн талаар мэдээлсний дийлэнх буюу 71% нь МАН-д, 27% нь АН-д ногдсон бол Шударга ёс эвсэл, ИЗНН-д ижилхэн 1% оногдсон байна.

- Далд сурталчилгааны В хэлбэрийн мэдээлэл 25 мин 46 секунд үргэлжилсний 52% нь МАН, 48% нь АН-ын мэдээлэл эзэлсэн байна.

**10.** “TV5” телевизийн мэдээний хөтөлбөрт шинжилгээ хийхэд 04:21:26 цагийн мэдээлэл нь сонгуультай холбоотой байв.

Цаг үеийн шинжтэй мэдээний хөтөлбөрөөр намуудыг хэрхэн мэдээлсэн талаар шинжлэхэд ИЗНН 41%, МАН 26%, Шударга ёс эвсэл 16%, АН 17% эзэлжээ. Бие даагчдын талаар 54 секунд мэдээлсэн нь 1%-д ч хүрээгүй байна.